

# Манмин Мэдээ

№ 57 2018 оны 2 сарын 25

## Эрх мэдэлт хүчит гар алчуураар дамжуулан гарах Ариун Сүнсний хүчит үйлс

Гэмт үйлдэл хорон муугаар дүүрсэн эцсийн энэ үед хүн төрөлхтөнийг аврах Есүс Христийн загалмайн хайрыг дамжуулах байхдаа “Есүс-Хүмүүс та нар тэмдэг, гайхамшигуудыг үзэхгүй бол ер итгэхгүй” (Иохан 4:48)д гэж айлдсан байдаг шиг амьд оршигч Бурханы хүч нөлөөг үзүүлж өгөх шаардлагатай байдаг.

Тийм ч учраас И Жей руг пастор нь Эзэний үгийн дагуу тэмдэг, гайхамшиг, эрх мэдэлт үйлсээр Бурхан үг, өөрөөр хэлбэл библийн үг сургаалийн үнэн бодит ба бүтээгч Бурханы хүч нөлөө, Есүс Христийн сайн мэдээг баглан бүх дэлхий даяарх үй олон ард түмнийг авралын замаар удирдаж байгаа билээ.

Шинэ гэрээний Үйлс номын 19:11-12д “Бурхан Паулын гараар дамжуулан ер бусын гайхамшигуудыг бүтээж байлаа. Алчуур, бүсийг нь түүнээс авч өвчтэй хүмүүст хүргэхэд өвчин нь эдгэж, муу сүнснүүд зайлж байв.” гэсэн байдаг.

Өнөө үед ч И Жей руг пасторын залбирал хийж өгсөн эрх мэдэлт хүчит гар алчуураар дамжуулан дэлхийн өнцөг булан бүрт Ариун Сүнсний хүчит үйлс илрэн гарч үүний мэдэрсэн олон хүмүүс Эзэнийг хүлээн авч жинхэнэ амь ба баяр хөөрийг олсон гайхамшигт ерөөлийн эзэд болсон юм. Бүх хүмүүс авралд хүрч, үнэнийг мэдэхийг хүсч буй Бурхан энэ эрх мэдэлт хүчтэй гар алчуураар дамжуулан авралын ивээлийг асар ихээр цутгасаар

байгаа билээ.

Энэ гар алчуураар дамжуулан гарах хүч нөлөө нь агуу гайхамшигтай бөгөөд Солонгост төдийгүй бүх дэлхий даяар Эдгэрэл ивээлийн цуглаан зохион байгуулагдаж, цаг хугацаа өнгөрөх тусам, И Жей руг пасторын эрх мэдэлт хүч өсөх тусам тэр эдгэрлийн хурдац улам ихсэж, илүү агуу үйлсүүд газар сайгүй бий болсоор байна.

Эцэс төгсгөлийн энэ үед амьдарч буй 7,6 тэрбум хүн төрөлхтөнийг Эзэний өвөр рүү удирдах хүртэл, 2018 энэ шинэ онд ч манай сүмийн орон нутагт болон дэлхий дахинаа сайн мэдээ тараах үүргээ агуу ихээр биелүүлэхийн төлөөх итгэлийн давшилт зогсолтгүй урагшилсаар байна.

## “Ховор тохиолдох мэдрэлийн өвчний улмаас биеийн доод хэсгийн саажилттай би тэргэнцэрээсээ босч алхсан нь”

Мак Жозеф Делфин итгэгч  
(25 нас, Филиппин, Габита Манмин сүм)

Саяхан л гэхэд католик сүмийн идэвхитэй гишүүн байсан манай гэрийнхэн Христчин болж, баяр хөөрөөр дүүрэн байхдаа одоогийн энэ гайхамшигт өөрчлөлтийн талаар төсөөлчиг чадахгүй байсан юм.

2017оны 9-р сар, Миний тархи маш хүчтэй өвдөж, цусны даралт ихэддэг болов. Тэгээд том эмнэлэгт шинжилгээ хийлгэхэд түүний хариу нь маш ховор

тохиолдох мэдрэлийн өвчин болох нь тогтоогдож, ямар нэгэн онцгой эмчилгээ байхгүй ба зөвхөн амин дэм, витамин л уух хэрэгтэй гэсэн юм. Эцэст нь бүх бие маань саажиж эхлэн нүүр ам, улаан хоолойн залгих рефлекс ч саажин гуурсаар л хооллодог болов.

Нэг сар орчим эмнэлэгт хэвтэж бие маань арай дээрдсэн ч урьдийн адил бие доод хэсэг саажилтаас болж би огт хөдөлгөж чадахгүй л байлаа. Бие болон сэтгэл санааны хувьд маш хэцүү, бүр цөхөрч байлаа. Тун ч удалгүй эмнэлэгээс цаашид хийх эмчилгээ байхгүй тул эмнэлэгээс гарахыг зөвлөсөн бөгөөд 10-р сарын 26ны өдөр эмнэлэгийн ойролцоо байх эмээгийнхээ гэрт байрлах боллоо.

Хоёр өдрийн дараа эмээгийн гэрт хэдэн хүмүүс ирж, “Бурханы хүч чадлаар хангалттай эдгэрнэ. Манай сүмийн тэргүүн пастор И Жей руг пасторын залбирлаар дамжуулан агуу гайхамшигтай эрх мэдэлт үйлс үй олноор гарч байгаа” гэж байлаа.

И Хи сон пасторын удирдлага дор “Эдгэрэл ивээлийн гар алчуурийн цуглаан” болох гэж байгаа тэнд агуу гайхамшигт эдгэрлийн хариулт маш их гарах болно гэдгийг сонсоод би гэрийнхнийхээ тусламжтайгаар Габита Манмин сүм рүү очсон юм.

2017оны 12-р сарын 3ны өдөр тэр эдгэрэл ивээлийн цуглаанд И Хи сон пастор нь И Жей руг тэргүүн пастораас залбирал авсан гар алчуур (Үйлс 19:11-12)-аар над дээр залбирал хийж өгсөн юм.

Би тэргэнцэрээс босож түшүүлэн алхаж чаддаг болсон байлаа. Энэ хэмжээний байхад л маш гайхамшигтай байсан ч цаашид илүү их гайхамшиг үргэлжилсээр байлаа. Гэртээ хариад би таяг тулан зөөлөн явдаг болсон бол хоёр өдрийн дараа ганцаараа зогсож, алхдаг болсон юм. Халлелүяа!

Ялангуяа насан туршдаа биеийн доод хэсгийн саажилттай байсан би залбирал авсаны дараа эв эрүүл урьдийн хэвээр болоход манай гэрийнхэн ч Эзэнийг хүлээн авсан юм. Энэ мэт намайг эдгээж өгч, манай бүх гэр бүлийнхнийг амийн замаар удирдаж өгсөн амьд оршигч Бурхандаа, бидний Эзэндээ бүхий л талархал ба алдрыг өргөө.



## Хинди болон Буддын шашинтан ч Эзэнийг хүлээн авсан билээ.

Хинди шашны сүсэгтэн байсан Энэтхэгийн Тара Синг (28 нас) итгэгч нь судасны хорт хавдраар шаналж байсан юм. Бүх биеийн тэнхээ тамир тасарч, үүний зэрэгцээ маш хүнд хэлбэрийн загатнаа зэрэг байнгын зовиур дотор амьдарч байсан юм. Тэгээд Энэтхэг Дели Манмин сүмд номлогдон ирж, гар алчуурын залбирал авсаны дараа

шинжилгээ өгөхөөр эмнэлэгт очиж, шинжилгээний хариу нь хорт хавдрын эс утсан талаар мэдсэн юм. Тэрээр “Жинхэнэ Бурхантай уулзаад маш их баяртай байна. Одооноос Христчин амьдралаар дахин төрж, эргэн тойрныхондоо намайг эдгээж өгч, шинээр өөрчилж өгсөн Эзэнийг дамжуулмаар байна” гэж Бурхандаа алдрыг өргөсөн юм.

Буддын шашны сүсэгтэн байсан Тайланд Куннан Жайкэу (38 нас) итгэгч Чианра Манмин сүмд эдгэрэл ивээлийн цуглаан болно гэдэг мэдээ сонсоод сонирхож очин оролцсоор Эзэнийг хүлээн авсан юм. Тэрээр “Эрх мэдэлт гар алчуураар залбирал авч маш олон хүмүүс эдгэрсэн тухайгаа

гэрчилж байгааг харлаа. Өнөөг хүртэл итгэж байсан шүтээнд хичээнгүйлэн үйлчиллээ ч ямар ч мэдрэмж байхгүй байсан гэтэл Бурхан үнэхээр амьд оршдог юм байна. Итгэхгүй байхын аргагүй баталгаа байхад мэдээж Есүс Христийг л хүлээн авна шүү дээ. Би залбирал аваад арьсны өвчнөөсөө эдгэрсэн ба одоо маш аз жаргалтай” гэж гэрчилж байлаа.



# Миний итгэл ба Бурханы өгсөн итгэл

“Есүс тэдний итгэлийг хараад, саа өвчтэй хүнд- Хүү минь, нүглүүд чинь уучлагдсан гэв. ... Би чамд хэлье. Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь гэсэнд мөнөөх хүн босож, тэр даруй дэвсгэрээ аваад, бүгдийн өмнүүр гарч явлаа. ...” (Марк 2:5-12).



И Жей руг пастор

Аврагч Эзэнээр ирсэн Есүс нь Галил нутгын Капернаумд байх үед болсон үйл явдал юм. Нэгэн саа өвчтэй хүн сураг дуулан, дөрвөн найзынхаа тусламжтайгаар Есүсийн байгаа гэрт очтол маш их хүмүүс байсан тул урд нь орох боломжгүй байлаа. Тэгтэл түүний дөрвөн найз гэр байшингийн дээврийг цоолж нүх гаргаад найзыгаа Есүсийн өмнө буулгасны үр дүнд Есүс тэдний итгэлийг харан шууд эдгээж өгсөн байдаг.

Энэ мэт итгэлээр боломжгүй зүйл гэж үгүй тул сүнс талаар ямар үйл явцыг туулж, асар хурдан хариултаа авах талаар тайлбарлая.

## 1. Хүний үүднээс өөрийн итгэлээ үзүүлж, “Итгэлийн багана”-г босгож хэрэгтэй.

“Хүний үүднээс үзүүлэх итгэл” гэж юу вэ? Бурхан үгээрээ тэнгэр газар, түмэн бодисыг бүтээж, Есүс бидний гэмийн төлөө загалмай дээр цовдлогдон нас бараад 3 хоногын дотор дахин амилсан гэдэгт итгэдэг гээд хариулт авна гэсэн үг биш юм. Сургаал үгийг сонсоод юм уу, библи уншдаг мэдлэг төдий итгэл байдаг. Гэхдээ энэ нь Бурханы өгдөг сүнс талын итгэлийг бий болгон хариулт авах хэмжээний “итгэлийн багана” бий болоход дөхөмтэй байдаг.

Есүсийн үед саа өвчтөн ба түүний нөхөд Есүс өвчнийг эдгээж байна гэсэн сураг сонсоод итгэж, тэр итгэлээ үйлдлээр харуулсан байдаг. Тэд Есүсийн өмнө очихын тулд

хичнээн их эрч хүч, ба бүх зүйлээ зориулан итгэлийн баганаа бат босгосон болохоор Есүс тэдний итгэлийн харж, “Хүү минь, нүглүүд чинь уучлагдсан” гэж айлдаж тэр даруй эдгээж өгсөн юм.

Өнөө үед ч мөн адил юм. Зүрх сэтгэлийн хариултаа авахын тулд өөрт байгаа итгэлээ үйлсээрээ илчилж, итгэлийн баганыг бэлтгэх хэрэгтэй байдаг. Бүтээгч Бурхан ба Есүс нь яагаад бидний аврагч болсон талаар зэрэг маш энгийн суурь сургаалиудыг сонсоод мэдлэг төдий ч гэсэн итгэлтэй болж байж эдгэрлийн гайхамшигийг мэдрэх боломжтой юм. Хэрэв Бурханд итгэдэг хүн бол осол аваарт орох юмуу, хүнд өвчин тусч, залбирал авахаар ирэхдээ “Төгс амралтын сахих ба Аравны нэгийн өргөл”-н талаар гэх наад захын хуулийн тушаалын тухай мэдэж, өөрийгөө эргэн харж, гэмшсэн үйлстэй байх ёстой юм (Иаков 2:26).

Энэ мэт итгэлээ үйлсээрээ илрэн гаргах үед Бурханы хариултыг авах итгэлийн баганаа баттай босгож чадах юм. Ямарч тохиолдолд чин сэтгэлээсээ залбирч, мацаг барин, заримдаа төлөвлөсөн залбирал ч хийх үе байдаг. Хүн тус бүрийн итгэлийн хэмжээний дагуу авралын зар тараах, үйлчлэх, халамжлах, тусламж өгөх гэх зэрэг Ариун Сүнсний удирдамжын дагуу сайны үйлсийг хийх чадвартай болдог юм.

Ингэж л үйлсээрээ итгэлээ харуулах үед, өөрөөр хэлбэл итгэлийн багана босгох үед л сүнс талын итгэлийг авч чадах юм.

## 2. Бурхан ба хүний хооронд гэмийн ханагүй байх ёстой.

Марк 2:5-р ишлэлд “Есүс тэдний итгэлийг хараад, саа өвчтэй хүнд- Хүү минь, нүглүүд чинь уучлагдсан гэв” гэсэн байдаг. Тэрээр сүнс талын хуулийг маш сайн мэддэг тул хариулж өгөхийн өмнө эхлээд гэмийн асуудлыг нь шийдэж өгсөнийг нь харж болно.

Исаиа 59:1-2д “Үзэгтүн, Эзэний мутар аварч чадахааргүй богино биш ээ. Түүний чих сонсож чадахааргүй дүлий бишээ. Харин та нарын гэм буруу нь та нарыг Бурханаас хагацуулан, та нарын нүглүүд Бурханы нүүрийг та

нараас далдалжээ. Тийм учраас Тэр сонсдоггүй.” гэж айлдсанчлан Бурханы өмнө гэмийн хана байгаа бол хүний үүднээс итгэлийн багана босгосон ч Бурханы хариулт авах боломжгүй юм.

Мөн итгэлийн багана босгоё ч гэсэн сатан өдрөг бус бодлоор уруу татаж, итгэлийн баганыг босгоход нь саад хийдэг. Хариулт авах тал дээр эргэлзэж, мэдлэг төдийхөн итгэлээ ч алдаж, өмнө сонсож байсан гэрчлэл, эсвэл өөрт тохиолдсон мэдрэмж нь санамсаргүй болсон зүйл мэт санагдаж эхлэдэг. Тиймээс итгэлээрээ хариулт тулд Бурханы өмнө гэмийн ханагүй байх ёстой.

Магадгүй “Би гэм хийсэн болохоор Бурхан хариулж өгөхгүй байх” гэж бодон хүч алдан, унадаг хүн байна уу? 1 Иохан 1:9д “Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.” гэсэн байдаг болохыг санах хэрэгтэй. Энэ үгийг санан, гэмийн хана байвал эхлээд өөрийн гэмийг Бурханы өмнө улайж, гэм нүглээсээ эргэн гэрэл дотор үйлдвэл Есүсийн ариухан цусаар бүх гэмээсээ уучлагдах болно.

Үүнчлэн Бурханы хариултыг авмаар байгаа бол гэмийн ханагүй болж, итгэлийн баганаа сайн босговол энэ нь хүний үүднээс хийх зүйлээ дууслаа гэсэн үг юм.

## 3. Бурханы өгдөг сүнс талын итгэлийн бэлгээр хүлээн авах хэрэгтэй.

Хичнээн хүний үүднээс итгэлийн баганаа бэлдсэн ч Бурханаас сүнс талын итгэлийг өгөхгүй бол хариулт авах боломжгүй юм. Марк номын 2:11д Есүс байшингийн дээврийг цоолон дэвсгэр дээрээ хэвтсэн чигээрээ бууж ирсэн саа өвчтөнг хараад “Би чамд хэлье. Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь” гэж тушаадаг. Энэ бол саа өвчтэй хүний ч биш, түүний дөрвөн найзын ч итгэл биш Есүсийн итгэлийн үг юм.

Саа өвчтөн болон түүний дөрвөн найзын бэлдсэн итгэлийн багана дээр Есүс сүнс талын итгэлийг холбож өгсөн юм. Тэгтэл гайхамшиг бий болсон юм. Удаан хугацаанд саа өвчнөөр зовж байж байсан хүн

хоромын зуур өөрийнхөө хөл дээр босоод дэвсгэрээ аваад чөлөөтэй алхаад гарч явсан юм. Энэ мэт зүрх сэтгэлдээ итгэх сүнс талын итгэл бууж ирвэл хоромхон зуур агуу гайхамшиг бий болдог.

Есүсийн хайртай шавь Петр нь усан дээгүүр алхах явдал нь ч өөрийн итгэлээр бий болсон зүйл биш юм. Петр бол Есүстэй хамт байвал гайхамшиг бий болно гэж итгэж байсан тул “Эзэн хэрэв Та хүсвэл надад тушааж, усан дээгүүр алхуулж өгөөч” гэж хэлэн итгэлийн багана босгосон юм. Есүс “Хүсч байна.” Ир гэж тушаахад дээрээс сүнс талын итгэл буун ирж, усан дээр алхаж эхлэсэн юм.

Гэвч Петр салхи салхилж байгаар мэдэрж, айснаараа усанд хөл алдан унасан юм. Петрийн тавьсан итгэлийн багана ганхаж, алга болмогц усан дээгүүр алхах гайхамшигт тэмдэг дууссан юм. Энэ бол сүнс талын хууль юм.

Тиймээс ямар ч зүйлд өөрөөс шалтгаалах бүх тал дээр итгэлийн багана босгож, “Миний итгэл дээр Бурханы өгсөн сүнсний итгэлийг буулгаж өгөөч” гэж залбирах хэрэгтэй юм. “Залбирал хийж, мацаг барьсан юм чинь” гэж өөрийн бодол, өөрийн арга, төлөвлөгөөгөөр муйхарлахын оронд чин сэтгэлээсээ Бурханд итгэн залбирал хийвэл дээрээс ирэх сүнс талын итгэлийг хүлээх хүлээлт бас хэрэгтэй юм.

Бурхан сүнс талын итгэлийг бэлгэ болгон өгөх тэр л үе бол хариултаа авах үе юм. Яг л ангамал газрын ган тайлах мэт, миний итгэл дээр Бурханы өгдөг сүнс талын итгэлээр бялхах үед ямар ч асуудал байсан шийдэгдсэн гайхамшиг болдог болохыг харж болно.

Хайрт итгэч та бүхэн, Сүнс сэтгэл сайжирсан хүний бүх зүйлд Бурхан хэрэгцээнийх нь дагуу нөлөөлж өгдөг (1 Иохан 3:21-22). Эсрэгээр нь Бурханы хаанчлалын төлөө, том хариултын төлөө итгэлийн баганыг ганцаараа босгох бус бүх нийтээрээ хамтаараа босголцор ёстой юм. Ийм сүнс талын хуулийг сайн суралцаад хүссэн болгондоо хариултаа авч, алдрыг өргөхийг Эзэний нэрээр хүсэн ерөөе.


## Монгол Манмин Сүм

### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

### Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С  
**Утас:** чуулганы- 5525-7637  
чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org  
www.gcntv.org

# Христийн анхилуун үнэрийг дэлгэрүүлэх амьдрал

2 Коринт номын 2:15д “Яагаад гэвэл бид аврагдаж буй болон мөхөж буй хүмүүсийн дотор Бурханд зориулсан Христийн анхилуун үнэр мөн.” гэсэн байдаг. Энэ мэтчилэн Христчин хүн Христийн анхилуун үнэрийг дэлгэрүүлэн, ертөнцийн гэрэл ба давс болон олон хүмүүсийг Эзэний өвөр рүү удирдах ёстой юм. Тэгвэл Христийн анхилуун үнэр гэж ямар үнэр вэ?

## Христийн анхилуун үнэр нь ‘Төлөв даруу болон үйлчлэл’-н анхилуун үнэр

Матай номын 20:28д Есүс “Үүнчлэн Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, үйлчлэхийн тулд ирсэн бөгөөд амиа олно төлөө золиос болгон өгөхөөр ирсэн билээ гэв” гэж айлдсанчлан хүмүүсийн Есүсээс мэдэрсэн зүйлс нь төлөв даруу ба үйлчлэл байсан юм.

Есүс “Би Эцэгийн дотор, Эцэг Миний дотор байгаа гэдэгт итгэгтүн. Эс бөгөөс үйлсийн учир итгэгтүн” (Иохан 14:11) гэсний дагуу Өөрийгөө Бурханы Хүү, аврагч Эзэн болохоо хүмүүст итгүүлэхийн тулд тэмдэг, гайхамшигт үйлсийг үйлдэн, агуу хүч нөлөөг үзүүлсэн юм.

Тэгсэн ч гэсэн өргөмжлүүлэхийн тулд бус харин ч Өөрийг төлөв болгон даруухнаар үйлчилсэн юм. Асар олон хүн Есүсийн өмнө ирж, заримдаа хооллож ч унтаж амарч чадахгүй байсан ч бүх хүнтэй чин сэтгэлээрээ хандаж байсан юм. Ийм төлөв даруу ба үйлчлэлийн анхилуун үнэр нь хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, өөрчилсөн юм. Энэ мэт Христчин хүнд ч гэсэн өөрийгөө даруу болгон үйлчлэх

төлөв даруухан үйлчлэлийн анхилуун үнэр гарах ёстой юм.

Албадлагаар эсвэл засарч өөрчлөгдсөн учраас үйлчлэх бус зүрх сэтгэлээсээ даруухнаар үйлчлэлийн үнэр аяандаа гарах үед л бусдын сэтгэлийг нээж, итгэл найдвар төрүүлж, авралын зар ч гэсэн бусдын зүрх сэтгэлд сайн суугдах боломжтой.

Хэрэв дээд хүний өмнө даруухнаар мэндэлдэг ч хойноос нь хараад өө эсв, муу талыг хайх юм уу, өөрөө дээд хүн байлаа гээд бусдаар мэндлүүлэх л гэж мэдсэн ч мэдээгүй, хараагүй мэт байгаа бол төлөв даруу болон үйлчлэлийн сэтгэлээс хол байгаа хэрэг юм.

Мөн өөрийнх буруу мөртлөө үүний улмаас зэмлүүлэхдээ сэтгэл тавгүйтэх, туних, өөрийнхөө төлөө шүүмжлэлд гомдоллож байвал өөрийгөө өргөмжлүүлэх, үйлчлүүлэх сэтгэл байна гэдгийг мэдэх хэрэгтэй юм. Ийм сэтгэлтэй учраас өөрийн дутагдал ил гарахад зэмлүүлэх шүүмжлүүлэх дургүй байдаг юм.

Хэрэв бусад хүн миний ойлгоход

хэцүү үгийг хэлэхэд ихэнх хүмүүс нь өөрийн үүднээс бодохдоо энэ зөв ярьж байна, буруу байна ийм тийм гэж дүгнэх тохиолдол их байдаг ч энэ ч бас бодит байдлаас өөр байх тал бий.

Түүнчлэн өөрийн сэтгэлийг даруу болгохгүй бусдаас өөрийгөө өндөрт тавьдаг сэтгэл тавгүйтэж бусадтай сөргөлдөж, маргаан болох үе бий. Харин өөрийгөө даруу болгож, бусдыг сэтгэлийг ойлгоё гэх үед бусадтай сөргөлдөх явдал байдаггүй. Бусад хүнийг ойлгохын тулд бусдын үгийг эцсээ хүртэл анхааралтай сонсох нь маш чухал юм. Тэр л үед бусдын сэтгэлийг ойлгох болдог. Хайрлагдахыг хүсч байна уу, хүлээн зөвшөөрөгдөхийг хүсч байна уу, илүү идэвхитэй байхыг хүсч байна уу зэрэг бусад хүний сэтгэлийг мэдэрсэнээрээ нийцүүлэн, тохирох хариултыг өгөх боломжтой юм.

Ингэж өөрийгөө даруу болгон үйлчилвэл тэр анхилан гарах Христийн үнэр нь зайлшгүй бусад хүний сэтгэлийг хөдөлгөдөг юм.

## Христийн анхилуун үнэр нь ‘Хайрын үнэр’

Эзэний шавь Петр гурван удаа Есүсийг үгүйсгэсэн ч Есүс түүнээс нүүр буруулаагүй юм. Харин ч түүний энэ сул дорой байдлыг ойлгож, уучилж өгөн түүнд дахин хүчийг өгсөн юм. Паул өмнө нь чуулганыг хавчиж, Эзэнд итгэдэг итгэгч нарыг барьж хорин алахаар явж байсан ч Эзэн Өөрөө түүнтэй уулзаж, уучилж өгөн элчээр томилсон байдаг. Ийм Эзэний хайр нь тэднийг өөрчилж өгөн элч Петр, элч Паул болгосон юм.

Үүний нэгэн адил бидний сэтгэл ч гэсэн Эзэний хайраар уян зөөлөн болсон юм. Эзэнийг мэдэх ч үгүй, итгэж ч чадахгүй бидний төлөө бүх биеэрээ ташуурдуулж, толгойдоо өргөст титэм зүүж, загалмайд гар ба хөлөө хадуулан цусаа урсган амиа зориулсан тэр хайрыг ухаарахад маш их уйлан, нулимстай нүдээр талархдаг байлаа Ингэж бидний төлөө төгс золиос болж өгсөн Эзэний хайр бидэнд илчлэгдэх үед бид Христийн анхилуун үнэрийг дэлгэрүүлэх боломжтой юм.

Хичнээн хариу харалгүй, өгсөөр дахин өгөхдөө харамгүй өгдөг тэр хайр,

миний гэм болон алдаа дутагдлыг Эзэн уучилсан шиг намайг хохироож, хэцүү байдалд оруулсан хүнийг ч уучлан хайрын анхилуун үнэрийг дэлгэрүүлэхэд бусдын сэтгэл зүрх ч хөдлөн өөрчлөгддөг. Сүнс талын хайр нь мөс шиг хүйтэн сэтгэлийг ч хайлуулж чадах ба хатуурсан сэтгэлийг ч зөөлрүүлэх чадалтай юм.

Ийм хайрын үнэр нь эцэстээ өөрөө ч бусдаар хайрлуулах болдог. Заримдаа “Би яагаад авч чадахгүй байгаа юм бол?” гэж бодож байгаа махан талын хайр хүндэтгэл нь удаан үргэлжлэхгүй болохыг ухаарах хэрэгтэй. Яагаад гэвэл махан талын байдал өөрчлөгдөх тусам эсвэл өөр хүн харвал энэ хайрлах сэтгэл хувирч болох учраас юм.

Бид хувиршгүй жинхэнэ хайрыг олон тулд хүний гол цөм болох сүнс сэтгэлээ хайр хүртэм өөрчлөх хэрэгтэй юм. Агтаг хорон муу байхгүй сайны сэтгэл, хувирч муудах махан талын бус сүнс талын зүрх сэтгэлтэй болж, Христийн анхилуун үнэрийг дэлгэрүүлвэл тэр хүн зайлшгүй хайрлагдах бөгөөд энэ жинхэнэ хайр байх болно.

Сүнсний сэтгэлээс гарах хайрын үнэр нь хэний ч сэтгэлийг хөдөлгөж чадах ба зөөлөн, дулаахан, мөн үнэнч байдлыг мэдрүүлэн тийм үнэрийг дэлгэрүүлэх нь хүний сэтгэлийг аяндаа нээж өөрөө ч мэдэлгүй зүрх сэтгэлээс гарах хайрыг өгч байдаг.

Энэ тэр сүнс сэтгэл нь хайр татам учраас түүний бүх зүйл эрхэм нандин байдаг нь хүрэтл жинхэнэ хайр байдаг. Бурхан Аав гэсэн бидний гадна төрх бус чин зүрхийг харж, бидний сэтгэл зүрхийг хайрладаг юм (1 Самуел 16:7). Үүний нэгэн адилаар бидэн бүхэн харагдахгүй байгаа Бурханыг хайрлана гэдэг нь зүрхээрээ Бурхан Аавд итгэж, хайрладаг гэсэн үг юм.

Сургаалт үгс 8:17д “Намайг хайрлагсдыг Би хайрлана. Намайг хичээнгүйлэн хайдаг нь Намайг олно” гэсний дагуу Бурханыг хайрладаг учир Түүний тушаалыг сахиж, үйлдвэл сүнс сэтгэл тань сайжирахын сацуу бүх ажил үйлс тань сайжирч, эрүүл энх байх ерөөл авч Бурханы хайрыг авч Бурхантай уулзсан хангалуун амьдралтай болох боломжтой.

# “Харц тулгарах яг тэр мөч, шээсний сүвний чулуужилтын цочмог хурц өвдөлт арилсан юм”

Юун Дү сог туслагч (38нас, 2-р их тойрог 12-бүлэг)



2017оны 12-р сарын 23ны өдөр үдийн 12 цагийн үед хөл бөмбөг тоглохоор талбай руу явсан юм. Тухайн үед цаг агаар нэлээн хүйтэн тул түр зуур бие халаалт хийж, хөл бөмбөг тоглож эхлэн 10-д минут орчим болсны дараа зүүн талын шилбэ “ток” гэж дуугаран бага зэрэг өвдөж байлаа. Шилбэ хавьд цус хурч, өвдөлт нь нэмэгдсээр байлаа. 30минут орчим сууж байгаад бэртээсэн хөлөө газар тавьж чадахгүй болтол өвдсөн тул баруун хөл дээрээ догонцон машиндаа суусан юм.

Тэгээд гар утсаар И Жей руг тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлыг автомат хариулагчаар гурав дөрвөн удаа авахад маш гайхалтай өвчин хөндүүр тэр дороо арилсан юм. Үүнийгээ тэргүүн пастортаа гэрчилбэ гэж бодож байтал 12-р сарын 24ны өдөр миний харьяалагдах 1-2р эрэгтэйчүүдийн багт тэргүүн пастортай уулзах боломж гарч ирсэн юм. Орой 7цаг 30минутын үед эхлэсэн тэргүүн пасторын сургаалийг сонсож байтал нуруу хөлрөх мэт болсон тул нээх тоолгүй өнгөрөөсөн юм. Сургаалийн цаг өндөрлөхөд “Өчигдөр тэргүүний пасторын залбирлаар хөлийн шилбэ болон булчин өвдөлтөөс

эдгэрч, одоо ямар ч зовиургүй сайн алхдаг болсон. Хоньчин минь баярлалаа” гэж гэрчилсэн.

Түүний дараа гэрийнхэнтэйгээ хамт гэртээ харихийн төлөө авто зогсоол руу явж байх зуур түүрүүний нурууны хэсгээр дахин өвдөж эхлэн, дотор эрхтэн яг л мушгих мэт маш хурц өвдөн алхаж ч чадахгүй хэцүү байдалд орлоо. Тэгээд сүм руу буцаж ороод WCDN (Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбоо)-ны оффист очин эхо зураг авахуултал, шээсний сүвийн чулуужилт болохыг олж мэдсэн юм. Биеэ барьж дийлэхийн аргагүй маш хүчтэй өвдөлтийг тэвчсээр тэргүүн пасторын байгаа газар руу залбирал авахаар ямар ч цаг авалгүй тэргүүн пасторын байгаа газар руу явлаа.

Энэ үед миний ухаан орон гаран байсан тул маш хүчтэй өвдөлтөөс болж богинохон хугацаа ч маш удаан юм шиг санагдаж байлаа. Тэнд олон итгэгч нар байсан ч тэр өвдөлтийг тэсч ядан газар хөлбөрч байлаа. Хэсэг хугацааны дараа тэргүүн пасторын залбирал авахаар өрөө рүү чиглэн явж байхад хэдийн миний тухай сонссон мэт хаалганыхаа дэргэд тэргүүн пастор зогсож байлаа.

Тэргүүн пастортай харц тулгарах яг тэр мөчид, миний нүднээс халуун гэмшлийн нулимс унан, өвдөлтийн тухай бодох ч сөхөө байсангүй. 23н жилийн турш сүмд явж байгаа ч тэргүүн пасторын дүрх төрх дэндүү намхан харагдаж байв. Яг л үр хүүхдээ өсгөх л гэж өөрийн бүх зүйлээ бүгдийг нь зориулсан аавын дүр төрх сэтгэлд минь бууж, итгэгч нарынхаа төлөө нулимстай залбирлаараа болон хайраараа үзүүлж өгсөн тэвчээрийн цаг хугацаа үнэхээх амар биш үйл явдал байсныг мөн миний төлөөх хайр байсныг ухаарсан цаг байлаа.

Тэргүүн пастор өвдөг сөгдсөн над руу хандан доошоо бөхийн миний нурууны баруун тал руу гар тавин залбирал хийж өгсөн юм. Хэдийнээ өвчин зовиур нь байгаагүй юм шиг алга болоход тэндээс маш хөнгөн босч ирсэн юм. Тэргүүн пастордаа бүлээхэн итгэлээр амьдарч байснаа гэмшиж дахин гал халуун эхлэхээ амлан гэрчиллээ. Хормын зуур энэ тэсэхийн аргагүй зовиураас эдгэрч дахин төрөх мэдрэмжийг өгсөн хайрын Бурхан Аавдаа бүх л талархал ба алдрыг өргөн залбирч өгсөн тэргүүн пастортаа гүн талархал илэрхийлбэ.

# “Нүдний бүрхэвчийн үрэвсэлээс эдгэрч, хараа сайжирч, нүдний шилээ хаян ерөөл хүртсэн юм”

Самуел Омонди Амата (29 нас, Кения Найроби Манмин сүм)



Би дунд сургуульд байхдаа нүднээсээ болж маш их хэцүү өвддөг байлаа. Нүдний болор цайх өвчний улмаас ахлах сургуульд байхдаа нүдний мэс засалд орсон дараа ч баруун нүднээсээ болж их л өвддөг байв. Миний баруун нүд маш мэдрэмтгий өчүүхэн доргилт болон салхи орвол өвдөж эхлэн хараа аажмаар муудаж байлаа. Үүнээс болоод би 3 сар орчим сургуульдаа явж чадаагүй юм. Зүүн талын нүдний хараа ч муудаж би нүдний шил зүүдэг боллоо. Цаашид нүдний бүрхэвчийн үрэвсэлтэй тул мэс засалд орохгүй бол нүдний эд эс үхмэл болно гэсэн юм.

2013 оны 1-р сарын эхээр санаандгүй байдлаар “Манмин мэдээ” сонинг олж харсан юм. Нагацын маань явдаг сүмийн сонин байсан бөгөөд юм унших дуртай болохоор тэр сонинг нэгд нэгэнгүй уншлаа. Тухайн үед нүдний өвчнөөр шаналж байсан болохоор тэр үү юу юунаас илүүгээр эдгэрэл тухай гэрчлэлээс маш ивээл авсан юм. Би ч гэсэн Бурханаас эдгэрэл авахыг хүсч нагацыгаа даган сүм рүү чиглэсэн өдөр бол 1-р сарын



бнд би Кения Найроби Манмин сүмийн гишүүн болсон юм.

Сүмийн хариуцагч болох Жон Мёон ху пастор И Жей руг пасторын залбирал хийж өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12) “Эдгэрэл ивээлийн цуглаан”-г удирдан явуулж байсан юм. Би ч хүсэн тэмүүлэн тэр хугацаанд бүхий л буруу үйлсүүдээ эргэн харж гэмшин чин сэтгэлээсээ бэлдэж байлаа.

Тун ч удалгүй 1-р сарын 20н болж “Эдгэрэл ивээлийн цуглаан” Жон Мёон ху пасторын гар алчуурын залбирлыг авах үед баруун болон зүүн нүдний өвчин алга болж, миний бие хойшоо яг савж унах гэж байгаа юм шиг болсон юм Түүний дараа жинхэнэ гайхамшиг эхлэсэн юм. Нүдний шилээ аваад хартал бүх хүмүүс болон эд

юмс маш тод харагдаж байлаа. Тэгээд ч зогсохгүй нөгөө нүдний шаналгаж байсан нүдний өвчин ч арилж хэвийн болсон байлаа. Халлелүяа.

Энэ мэт Бурхантай гал халуун уулзсан би тэр ивээлд үнэхээр талархаж хичээнгүйлэн итгэлээр амьдарч байна. 2015оны 9-р сард төрийн албан хаагчийн анкет бөглөөд ярилцлагад орсон дараа Жон Мёон ху пасторын залбирал авсан юм.

Түүний дараахан Эм үйлдвэрлэлийн судалгааны төвд гэрээт ажилчнаар орсон юм. Түүний дараахан үндсэн ажилтан болохын тулд “2 удаагийн онцгой Даниел залбирлын цаг”-т оролцон чин сэтгэлээс залбирсан ба тухайн үндсэн ажилтан болоход бодит байдал орон тооны хувьд хэцүү байсан ч Бурхан миний залбиралд хариулж өгсөн юм. 2017оны 3-р сард үндсэн ажилтан болж цалин ч гэсэн нэмэгдсэн ерөөл авсан юм.

Энэ дэлхийд хэн ч намайг өвчний зовиураас ангижруулж чадаагүй байхад Бурхан миний амьдралын бүхий л асуудлыг шийдэж өгсөн юм. Хоньчны орон зайд ерөөж өгсөн Гуравын холбооны Бурхандаа бүхий л талархал ба алдрыг өргөе.

## УБ Ариун баярт мэдээ чуулган

### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

### залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

### Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

## Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
www.manminnews.com  
e-mail: manmininen@manmin.kr  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин